

2016.10.20

ТАНИЛЦУУЛГА

“Монгол улсын виз олгох журам”-ын шинэчилсэн
найруулгын төслийн талаар

Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-аар гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз, визийн зөвшөөрөл олгох, визийн ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулагч, давхар харьяалал үүсгэсэн болон Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэнд виз олгоход таатай нөхцлийг бүрдүүлэх, гадаадын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх, виз олгох нөхцлийг хөнгөвчлөхөд журмыг шинэчлэн батлах шаардлага гарч байна.

Журмыг шинэчлэн баталснаар гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэдгээрийг уригч иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн үйлчилгээ хөнгөн шуурхай болохоос гадна дараах үр дүн гарна:

1. Төрийн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах, хөрөнгө оруулагч, Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүн оршин суух тохиолдолд зохих ангиллаар орж ирэхийг шаарддаг байсан.

Журамд өөрчлөлт оруулснаар түр хугацаагаар ирсэн эдгээр гадаадын иргэд Монгол Улсад оршин суух хүсэлт гаргасан тохиолдолд визийн ангиллаа өөрчлөн оршин суух таатай нөхцлийг бүрдүүлсэн.

2. Монгол Улсын иргэний 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд тус улсад 90 хүртэл хоногоор хувийн хэргээр зорчиход визийн зөвшөөрөлгүйгээр виз олгож байсан зохицуулалтын хүрээг өргөсгөн Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнд “Н” ангиллын бүх төрлийн визийг зөвшөөрөлгүйгээр олгохоор тусгалаа.

3. Журамд заасан зарим эрх хязгаарласан, хориглосон заалтуудыг хассанаар гадаадын иргэн виз мэдүүлэх боломжийг хялбаршуулсан. Тухайлбал, гадаадын иргэн виз мэдүүлэхээс өмнө 3 сарын хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн тохиолдолд виз олгодоггүй байсан хугацааг 1 сар болгож багасгасан, мөн түр ирэгчид олгох олон удаагийн визийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох журамд заасан зөрчлийг сүүлийн 3 жилд 2 буюу түүнээс дээш удаа гаргаж байсан гадаадын иргэнд олгохгүй байх зэрэг хязгаарлалтыг хассанаар захиргааны зөрчил гаргасан гадаадын иргэн хэдийд ч виз мэдүүлэх боломжтой болсон.

Мөн түр ирэгч гадаадын иргэний визийн сунгалт хоорондын хугацаа 6 сараас доошгүй байх хязгаарлалтыг хассан.

4. Виз хүсэхэд бүрдүүлэх материалыг цөөлж визийн ангиллаас хамааран журамд заасан бичиг баримтаас сонгож бүрдүүлэхээр заасан. Мөнвиз хүсэгч мэдүүлсэн мэдээллийн үнэн зөвийг нотлох үүргийг хүлээх,виз олгоход шаардагдах үндэслэл бүхий баримтыг бүрдүүлэхээр заасан.

5. Гадаадын иргэн, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох, сунгуулах хүсэлтээ цахимаар мэдүүлэх эрх зүйн зохицуулалтыг журамд нэмж тусгалаа.

Энэхүү журмыг шинэчлэн батлахад иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ,холбогдох хууль тогтоомжийн заалтыг хөндөөгүй болно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оныдугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын виз олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Очир нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ж.ЭРДЭНЭБАТ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын виз хүссэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-д виз, визийн зөвшөөрөл олгох, визийн ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгоход Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг мөрдөхөд энэ журам үйлчлэхгүй.

Хоёр. Визийн зөвшөөрөл олгох

2.1. Дипломат, албан зэргийн бүх төрлийн визийн болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7-д заасан ангиллын 30 хүртэлх хоногийн орох зориулалтын нэг болон хоёр удаагийн энгийн зэргийн визийн зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад визийн зөвшөөрлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

2.3. Визийн зөвшөөрөл нь тухайн визийн зөвшөөрөл олгогдсон өдрөөс 90 хоногийн дотор хүчинтэй байна.

2.4. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь визийн зөвшөөрөл олгосон тохиолдолд энэ тухай Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт дахь албанд мэдэгдэнэ.

2.5. Уригч нь хилийн боомт дээр гадаадын иргэнд виз олгуулах хүсэлтээ тухайн гадаадын иргэнийг Монгол Улсад ирэхээс 3 хоногийн өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.6. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Засгийн газрын дангаараа гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн нь албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих ангиллын визийн зөвшөөрөл авна.

2.7. Визийн зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдүүлгийн хуудас бөглөн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.7.1. уригчийн хүсэлт;

2.7.2. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичиг (цаашид “паспорт” гэх)-ийн хуулбар;

2.7.3. хөдөлмөр эрхлэхээр ирэх гадаадын иргэнд эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас олгосон зөвшөөрөл;

2.7.4. байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт;

2.7.5. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн, төрсний гэрчилгээний хуулбарыг баталгаат орчуулгын хамт.

2.7.6. *Монгол Улсад байхад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаа*

2.8. Түр ирэгчийн олон удаагийн виз, визийн зөвшөөрөл хүсэхэд энэ журмын 2.7-д зааснаас гадна уригч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, гаалийн бүрдүүлэлт, татварын байгууллагын тодорхойлолт зэрэг үндэслэл бүхий бичиг баримтыг бүрдүүлнэ.

2.10 *Виз олгох эрх бүхий байгууллага нь Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнд “Н” ангиллын бүх төрлийн визийг зөвшөөрөлгүйгээр олгоно.*

Гурав. Виз, визийн зориулалт, төрөл, хугацаа

3.1. Визийн хуудсанд дараах мэдээллийг тэмдэглэнэ:

3.1.1. гадаадын иргэний зураг (photo);

3.1.2. визийн хүчинтэй хугацаа (enter before);

3.1.3. байх хугацаа (duration of stay);

3.1.4. визийн зэрэг (level);

3.1.5. визийн зориулалт (visa type);

3.1.6. визийн ангилал (classification);

3.1.7. визийн төрөл (entries);

3.1.8. гадаадын иргэний овог, нэр (full name);

3.1.9. иргэний харьяалал (citizenship);

3.1.10. гадаадын иргэний паспортын дугаар (passport number);

3.1.11. олгосон огноо (date of issue);

3.1.12. олгосон газар (issued at);

3.1.13. тусгай тэмдэглэл (remarks).

3.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.5-д заасан зориулалтын визийг дараах гадаадын иргэнд олгоно:

3.2.1. түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд “орох”;

3.2.2. албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсаас гараад буцаж ирэх бол “гарах-орох”;

3.2.3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнд “дамжин өнгөрөх”.

3.3. Визийн зориулалтыг визийн хуудсан дээр дараах байдлаар тэмдэглэнэ:

3.3.1. “орох” визийг “Entry”;

3.3.2. “гарах-орох” визийг “Re entry”;

3.3.3. “дамжин өнгөрөх” визийг “Transit”.

3.4. “Орох”, “гарах-орох”, “дамжин өнгөрөх” зориулалтын виз нь нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байна.

3.5. Визийн төрлийг визийн хуудсан дээр дараах байдлаар тэмдэглэнэ:

3.5.1. нэг удаагийн визийг “Single”;

3.5.2. хоёр удаагийн визийг “Double”;

3.5.3. олон удаагийн визийг “Multiple”.

3.6. Визийн хүчинтэй хугацаа гэдэг нь орох, дамжин өнгөрөх бүх төрлийн визийн хувьд виз олгосон өдрөөс Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэлх хугацаа бөгөөд визийн хуудасны “enter before” хэсэгт тэмдэглэнэ.

3.7. Нэг болон хоёр удаагийн “гарах-орох” визийн хүчинтэй хугацаа нь гадаадын иргэний Монгол Улсаас гараад буцаж ирэх хугацаа бөгөөд гадаад улсад байх хугацааг мөн тодорхойлно. “Гарах-орох” визийн хүчинтэй хугацааг визийн хуудасны “enter before” хэсэгт тэмдэглэнэ.

3.8. Виз нь дараах хугацаанд хүчинтэй байна:

3.8.1. нэг болон хоёр удаагийн “орох” виз 90 хоног;

3.8.2. нэг болон хоёр удаагийн “гарах-орох” виз 180 хүртэл хоног;

3.8.3. нэг болон хоёр удаагийн “дамжин өнгөрөх” виз 90 хоног;

3.8.4. түр ирэгчийн болон дамжин өнгөрөх олон удаагийн визийн хүчинтэй хугацаа нь 183 буюу 365 хоног.

3.9. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгох “гарах-орох” бүх төрлийн визийн хүчинтэй хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хэтрэхгүй байна.

3.10. Визийн “байх хугацаа” гэдэг нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр орж ирснээс хойш тус улсад байх хугацаа бөгөөд визийн хуудасны “Duration of stay” хэсэгт тэмдэглэнэ.

3.11. Визэнд бичигдсэн “байх хугацаа” нь дараах хугацаатай байна:

3.11.1. нэг болон хоёр удаагийн орох виз 90 хүртэл хоног;

3.11.2. түр ирэгчид олгох олон удаагийн виз 30 хоног;

3.11.3. бүх төрлийн “дамжин өнгөрөх” виз 10 хүртэл хоног.

Дөрөв. Виз олгох

4.1. Гадаадын иргэн нь ирсэн зорилгодоо нийцсэн ангилал бүхий виз авсан байна.

4.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасны дагуу Монгол Улсад албан хэргээр оршин суух болон түр ирэх гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага виз, визийн зөвшөөрөл олгоно.

4.3. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул нь гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хүсэлтийг үндэслэн виз олгоно.

4.4. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул байхгүй улсаас ирж байгаа гадаадын иргэнд олон улсын хилийн боомт дээр орох виз олгоно.

4.5. Шаардлагатай тохиолдолд хилийн боомтод Монгол Улсад оршин суугч гадаадын иргэнд уригчийн хүсэлтийг үндэслэн “гарах-орох” виз олгоно.

4.6. “Дамжин өнгөрөх” визийг тухайн гадаадын иргэний очих улсын виз болон тийзийг үндэслэн олгоно.

4.7. *Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн нь гэрээнд зааснаас илүү хугацаагаар зорчих, оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих ангиллын визийг урьдчилан авна.*

4.8. Виз хүсэгч виз мэдүүлэхээс өмнө хураамжийг урьдчилан төлөх бөгөөд виз олгохоос татгалзсан тохиолдолд хураамжийг буцаан олгохгүй.

4.9. Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлахаар ирэх гадаадын иргэн виз мэдүүлэхдээ мэдүүлгийн хуудас бөглөн 3.5х4.5см хэмжээтэй 1 хувь цээж зураг, хүчин төгөлдөр паспортын хамт бүрдүүлнэ.

4.10. *Энэ журмын 4.9-т зааснаас бусад виз хүсэгч гадаадын иргэн нь мэдүүлгийн хуудас бөглөн, визийн ангиллаас хамааран дараахь бичиг баримтаас сонгон бүрдүүлнэ:*

4.10.1. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт;

4.10.2. уригчийн хүсэлт;

4.10.3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан байгууллагаас олгосон визийн зөвшөөрөл, хувийн урилга;

4.10.4. 3.5х4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;

4.10.5. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээний эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

4.11. *Гадаадын иргэний хүчин төгөлдөр паспортад визийг нааж, эрх бүхий албан тушаалтан **гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулна.***

4.12. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.3-т заасан хавсралт нь паспортын дэлгэмэл хуудасны хэмжээтэй байна. Хавсралтын нэг талд нь тухайн гадаадын иргэний эзэмшиж байгаа паспортын хуулбарыг хийж, нөгөө талд нь олгосон визийг наана.

4.13. Визэнд дараах албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна:

4.13.1. гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан газрын захирал, дэд захирал;

4.13.2. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, консулын хэлтсийн дарга, консулын албан тушаалтан, өргөмжит консул;

4.13.3. гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, түүний эрх олгосон албан тушаалтан.

4.14. Визийн мэдүүлгийн хуудасны загварыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

4.15. Виз бүхий паспортыг үрэгдүүлсэн, солиулсан гадаадын иргэнд визийн хуудасны үнийг төлүүлэн визийг дахин олгоно.

4.16. *Гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авсан тохиолдолд түүнд олгосон түр ирэгчийн олон удаагийн визийн байх хугацаа, зориулалтыг өөрчилж олон удаагийн визийн хүчинтэй хугацаагаар оршин суух зөвшөөрөлд нийцүүлэн визийн хуудасны үнийг төлүүлэн олгоно.*

4.17. *Гадаадын иргэнд зөвшөөрөлгүй виз олгосон тохиолдолд визийг хүчингүй болгож зохих ангиллын визийн хуудасны үнийг төлүүлэн олгоно.*

4.18. Визийн хуудсанд тэмдэглэх мэдээллийг буруу тэмдэглэснээс визийн хуудас хүчингүй болсон тохиолдолд визийн хуудасны үнийг виз үйлдсэн ажилтан төлнө.

Тав. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах,
визийг хүчингүй болгох

5.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна дараахь үндэслэлээр виз, визийн зөвшөөрлийг олгохоос татгалзана:

5.1.1. гадаадын иргэн виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхээс өмнө 1 сарын хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан зөрчил гаргаж захиргааны шийтгэл хүлээсэн;

5.1.2. хуурамч бичиг баримт бүрдүүлэн мэдүүлсэн;

5.1.3. худал мэдүүлэг өгсөн.

5.2. Визийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

5.2.1. визийг хуурамчаар үйлдсэн;

5.2.2. уригчийн хүсэлтийг үндэслэн;

5.2.3. хууль хяналтын байгууллагын саналыг үндэслэн;

5.2.4. виз буруу бичигдсэн;

5.2.5. албадан гаргаж байгаа бол;

5.2.6. визийн зөвшөөрөлгүй олгосон;

5.2.7. оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон бол.

5.3. Визийг хүчингүй болгохдоо визийн хуудас дээр “хүчингүй” буюу “cancelled” гэсэн дардас дарна.

5.4. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан бол виз, визийн зөвшөөрөл хүсэгч 30 хоногийн дараа дахин хүсэлт гаргаж болно.

Зургаа. Визийн хугацааг сунгах, ангилал өөрчлөх

6.1. Визийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

6.2. Гадаадын иргэн визийн байх хугацааг сунгуулах хүсэлтээ уг хугацаа дуусахаас ажлын 4 хоногийн өмнө гаргана.

6.3. *Оршин суугч гадаадын иргэн оршин суух хэлбэрээ өөрчлөх хүсэлт гаргасан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан үзэж оршин суух хэлбэрт нийцүүлэн визийн ангиллыг өөрчилнө.*

6.4. *Төрийн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах, хөрөнгө оруулагч, Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүн түр ирэгч нь оршин суух хүсэлт гаргасан тохиолдолд визийн ангиллыг өөрчилнө.*

Долоо. Бусад зүйл

7.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42.1-д заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулсан гадаадын иргэний паспортад гарах хугацааг заасан "хасалт" хийнэ.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хасалт нь захиргааны шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 10 хүртэл хоногийн хугацаатай байна. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж Монгол Улсаас гарах үүрэгтэй.

7.3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага визийн ангилал өөрчлөх, бүртгэх, хасалт хийх тэмдгийн загварыг, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага визийн баталгаажуулах тэмдэг, ангилал өөрчлөх, бүртгэх, хасалт хийх, хүчингүй болгох тэмдгийн загварыг тус тус баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

7.4. Шаардлагатай тохиолдолд виз, визийн зөвшөөрөл олгохдоо хууль хяналтын байгууллагын саналыг үндэслэнэ.

7.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь виз, визийн зөвшөөрөл олгох үйлчилгээг ажлын тав хоногт, яаралтай үйлчилгээг ажлын гурав хоногт багтаан гүйцэтгэнэ.

7.6. *Виз хүсэгчийн паспортын хүчинтэй хугацаа 6 сараас доошгүй байна.*

7.7. *Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааны нийлбэр тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд оршин суух зөвшөөрөл авна.*

7.8. Виз, визийн зөвшөөрөл хүсэгч нь мэдүүлгийн хуудас, бичиг баримтыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө.

7.9. *Гадаадын иргэн, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох, сунгуулах хүсэлтээ цахимаар мэдүүлж болно.*

---oOo---